ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ



2026 JAN

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

АГУУЛГА

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ 1

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ 2

2.1. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал 2

2.2. АНУ-ын эдийн засаг 3

2.3. БНХАУ-ын эдийн засаг 4

2.4. 1-р сарын онцлох үйл явдал 4

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ 5

3.1. Эдийн засгийн өсөлт, инфляцын түвшин 5

3.2. Мөнгөний үзүүлэлт 7

3.3. Улсын төсөв 8

3.4. Гадаад худалдаа 10

3.5. Төлбөрийн тэнцэл, ханш 12

График, хүснэгтүүдийн жагсаалт

График. 1 ОУВС-ын инфляцын төсөөлөл 2
График. 2 ОУВС-ын дэлхийн улсуудын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 3
График. 3 Монголын эдийн засгийн өсөлт 2025 оны 3-р улирал 6
График. 4 Инфляц ба бодлогын хүү 7
График. 5 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 8
График. 6 Улсын төсвийн гүйцэтгэл 8
График. 7 2026 төсвийн төсөл, төсвийн орлогын бүрэлдэхүүн, их наяд төгрөг 9
График. 8 Экспорт, импортын өсөлт 10
График. 10 Импортын бүтээгдэхүүн 11
График. 9 Экспортын орлого 11
График. 11 Нүүрсний экспортын биет хэмжээ 11
График. 12 Төлбөрийн тэнцэл, ГВАН, ханш 13

Хүснэгт. 1 Эдийн засгийн өсөлтөд салбаруудын оролцоо 6

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2025Q3	2025Q2	2024Q3	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	24,250	15,257	22,891	5.9%
Ажилгүйдлийн түвшин	%	5.5%	4.5%	6.1%	
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2972	2951	2617	13.6%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2025M12	2025M11	2024M12	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам.доллар	15,701	13,742	15,783	-0.5%
Зэс	сая ам.доллар	5,809	5,067	3,319	75.0%
Нүүрс	сая ам.доллар	5,561	4,897	8,535	-34.8%
Нийт импорт	сая ам.доллар	-11,312	-10,211	-11,615	-2.6%
Хэрэглээ	сая ам.доллар	-3,519	-3,209	-3,546	-0.8%
Түүхий эд	сая ам.доллар	-4,696	-4,281	-4,957	-5.3%
Аж үйлдвэрлэл	сая ам.доллар	-960	-849	-933	2.9%
Шатахуун	сая ам.доллар	-2,118	-1,855	-2,162	-2.0%
Тэнцэл	сая ам.доллар	4,389	3,532	4,169	5.3%
Түүхий эдийн үнэ					
Зэс	$/тонн	12,423	11,189	8,768	41.7%
Нүүрс (хилийн)	$/тонн	67	66	107	-38.0%
Алт	$/трой унц	4,319	4,239	2,625	64.6%
Газрын тос	$/баррел	60.9	62.0	71.1	-14.4%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2025M12	2025M11	2024M12	
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	-1,232	-1,776	-920	33.8%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	30,058	25,603	29,671	1.3%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	31,289	27,379	30,591	2.3%
Мөнгөний бодлого					
M2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	47,054	45,801	43,276	8.7%
ХҮИ (С2023)	индекс	118.8	118.1	110.55	7.5%
Бодлогын хүү	%	12%	12%	10%	
Хүү ба ханш					
Ам долларын ханш	Төгрөг/$	3,557	3,554	3,420	4.0%
Төгрөгийн хадгаламж	%	12.0%	11.7%	11.9%	
Валютын хадгаламж	%	3.6%	3.9%	4.1%	
Төгрөгийн зээл	%	17.2%	17.4%	16.9%	
Валютын зээл	%	9.8%	9.4%	9.6%	
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам.доллар	7,005	5,886	5,510	27.1%

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ

2.1. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал

2025 оны хувьд тарифаас үүдэлтэй худалдааны чиг хандлага өөрчлөгдөж геополитикийн нөхцөл байдал улам хурцадсан жил болж өнгөрлөө. Олон улсын валютын сангийн “Дэлхийн эдийн засгийн төлөв байдал”-ын тайланд эдгээр эрсдэлүүд ирэх онд болон дунд хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгаа талаар дурджээ.

График. 1 ОУВС-ын инфляцын төсөөлөл



Эх сурвалж: WEO 2026 JAN, IMF

Дэлхийн инфляцын түвшин 2025 онд 4.1% байсан бол 2026 онд 3.8%, 2027 онд цаашид 3.4% болж тогтвортой буурах төлөвтэй байна. Хөгжсөн эдийн засагтай улсуудын хувьд инфляц илүү хурдан саарч, 2026–2027 онуудад төв банкнуудын зорилтот түвшинд ойртох төлөвтэй байгаа бол хөгжиж буй орнуудын инфляц харьцангуй өндөр байх боловч мөн адил аажмаар буурах хүлээлттэй байна.

Улс орнуудын хувьд дотоод эрэлт сул байгаагийн зэрэгцээ ажилгүйдлийн түвшин нэмэгдэх, эрчим хүч болон түүхий эдийн үнэ буурах, мөн тарифаас шалтгаалж мөнгөний бодлогын хатуу төлөв үргэлжилж байгаа зэрэг нь инфляц буурах гол хүчин зүйлс болж байна. Мөн үйлдвэрлэгчдийн хувьд цалингийн дарамт суларсан нь үнэ өсгөх шаардлагыг бууруулж инфляц олон улсын хэмжээнд алгуур саарч байна.

2025 оны геополитикийн хурцадмал байдал нь санхүүгийн зах зээл, нийлүүлэлтийн сүлжээ, түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлж, дэлхийн эдийн засагт тодорхойгүй байдлыг нэмэгдүүлсэн. Улмаар эдийн засгийн идэвхжилийн дэмжихийн тулд хөгжсөн орнууд мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж байсан бол хөгжиж буй, түүхий эдээс хамаарал өндөртэй улсуудын хувьд олон улсын худалдаанд гарч буй өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлээс сэргийлж мөнгөний хатуу бодлого явуулсан жил боллоо.

График. 2 ОУВС-ын дэлхийн улсуудын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эдийн засгийн өсөлтийн төсөөллийн хувьд 2026 онд 3.3%, 2027 онд 3.2% болж буурах хүлээлттэй байна. 2026 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөхөөс сайжруулсан нь хувийн секторын идэвхжил, технологид оруулсан хөрөнгө оруулалтаас үүссэн бүтээмжийн өсөлт, цаашлаад худалдааны эрсдэл төсөөлж байснаас бага байж, улс орнуудын засгийн газрын эдийн засгаа дэмжих бодлого үр нөлөөгөө үзүүлж байгаа зэргээр тайлбарлагдаж байна.

Улс орнууд тогтвортой хөгжлийг хадгалахын тулд төсвийн нөөцийг нэмэгдүүлэх, үнийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, эдийн засгийн тодорхойгүй байдлыг бууруулах нэн шаардлагатай гэж ОУВС-ын тайланд онцолжээ.

2.2. АНУ-ын эдийн засаг

ОУВС-ийн таамаглалаар АНУ-ын эдийн засгийн өсөлт 2026 онд 2.4 хувиар өсөх хүлээлттэй байна. Харин АНУ-д амьжиргааны өртөг өндөр байгаа нь өрхийн судалгаанд дурдагдсан хамгийн чухал асуудал хэвээр байна. Мөн ирэх жилд өрхүүдийн инфляцын талаарх хүлээлт өндөр байгаагаас гадна үйлдвэрлэлийн түүхий эд, материалын үнийн өсөлт инфляцад дарамт үзүүлж байгаа гол хүчин зүйл болоод байна. 2026 онд инфляцын өсөлтөөс шалтгаалж Холбооны Нөөцийн банк бодлогын төлөвийг зөөлрүүлэх орон зай хязгаарлагдаж байгаа хэдий ч ажилгүйдлийн түвшнийг бууруулах, эдийн засгийг дэмжих зорилгоор бодлогын хүү буурах хүлээлт өндөр байна. Холбооны нөөцийн банк 2025 оны 12 сард бодлогын хүүг 25 суурь нэгжээр бууруулж, 3.5%-3.75% болгосон ба Төв банкны зүгээс бодлогын хүүг эдийн засгийг дэмжих зорилгоор 2026 онд 100 суурь нэгжээс дээш хэмжээгээр бууруулах шаардлагатай гэж үзэж байна.

2.3. БНХАУ-ын эдийн засаг

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2025 онд 5.0%-д хүрч засгийн газрын зорилтот түвшинд хүрлээ. 2025 оны цэвэр экспорт ДНБ-ий өсөлтийн 33 орчим хувийг бүрдүүлсэн нь 1997 оноос хойших хамгийн өндөр түвшин болсон ба БНХАУ эдийн засгийн өсөлтөө экспортоор дэмжиж байгааг илтгэж байна. 2026 онд идэвхтэй төсвийн тэлэх бодлого болон зохистой уян хатан мөнгөний бодлого баримтлахаа баталсан ба БНХАУ-ын Ардын банк энэ онд банкнуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээ болон хүүг бууруулах төлөвтэй байна. Гэвч үндсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 3.8 хувиар буурсан буюу орон сууцны зах зээл уналттай хэвээр байгаагаас шалтгаалж дефляцийн дарамт үргэлжилсээр байна. Мөн АНУ-тай 2025 оны 11 сард хийсэн 1 жилийн худалдааны тохиролцооны үр дүнд Хятадын бараанд ногдох АНУ-ын бодит тарифын түвшин буурснаар худалдааны эрсдэл 2026 оны хувьд буурах хандлагатай байна.

Ийнхүү эдгээр эрсдэл болон боломжийг харгалзан үзэж ОУВС-ын таамаглалаар БНХАУ-ын эдийн засаг 2026 онд 4.5 хувиар өснө гэсэн хүлээлттэй байна.

2.4. 1-р сарын онцлох үйл явдал

АНУ болон Гринланд хоорондын зөрчилдөөн

АНУ Гринландад цэрэг байршуулсан НАТО-гийн зарим оронд тариф ногдуулахаа зарласнаар геополитик болон худалдааны хурцадмал байдал нэмэгдсэн. Энэ нь Гринландын газрын ховор элементийн стратегийн ач холбогдол, Арктикийн аюулгүй байдалтай холбоотой. Харин 2026 оны Дэлхийн эдийн засгийн форумын үеэр АНУ дипломат арга барилд шилжиж, тарифыг түр зогсоон, цэргийн хүч хэрэглэхгүй гэдгээ мэдэгдсэнээр хурцадмал байдал тодорхой хэмжээнд намжлаа. Албан ёсны гэрээ байгуулагдаагүй ч талуудын хооронд яриа хэлэлцээг үргэлжлүүлэх суурь нөхцөл бүрдсэн юм.

БНХАУ нь 2026 оны 1-р сарын 1-нээс эхлэн 300 орчим төрлийн гангийн бүтээгдэхүүний экспортын лицензийг идэвхжүүлэхээр болсон.

Энэ нь түүхий ган болон нүүрсний дотоод эрэлтийг бууруулж, экспортыг 5–20%-аар багасгах, гангийн үйлдвэрлэлийг 0.55–2.2%-аар бууруулах магадлалтай.

Гангийн зах зээлийн хувьд 11, 12-р саруудад улирлын шинжтэй эрэлтийн сулрал улам нэмэгдэхийн хэрээр гангийн үйлдвэрлэл буурах төлөвтэй байна. БНХАУ-ын хойд бүс нутагт өвлийн нөхцөлөөс шалтгаалан барилгын ажил бараг бүрэн зогссон бол өмнөд бүс нутгийн төслүүд ихэнхдээ дуусах шатандаа оржээ. Үүний зэрэгцээ боловсруулах үйлдвэрлэлийн зориулалттай гангийн эрэлт мөн улирлын шинжтэй суларч байна. Эцсийн хэрэглэгчийн эрэлт буурч, зарим бүтээгдэхүүний ангилалд алдагдал нэмэгдэж буй дарамтаас үүдэн үйлдвэрүүд засвар үйлчилгээний хугацааг сунгаж, үйлдвэрлэлийн хэмжээг танах арга хэмжээ авч байна.

Эдгээр гангийн экспортыг хязгаарлах чиглэлийн бодлого нь хамгийн түрүүнд гангийн үйлдвэрлэлийг бууруулж үнийг тогтворжуулах нөлөөтэй ба энэ нь Монгол улсын нүүрсний хилийн үнэд нөлөөлөх магадлалтай.

Түүхий эдийн зах зээл

Алтны үнэ **$5,000-ыг** давж 2026 оны 1-р сарын байдлаар түүхэн дээд хэмжэнд хүрлээ. Геополитик, зах зээлийн эрсдэл өндөр нөлөө үзүүлсэн ба 2026 онд ч үнэ өсөх хандлагатай байгааг шинжээчид онцолж байна.

Зэсийн үнэ 2026 оны 1-р сарын байдлаар тогтвортой түвшинд хадгалагдаж байна. Үнийн түвшин олон улсын бирж дээр нэг тонн нь ойролцоогоор **$13,000-д** хүрсэн ба эрэлт их хэдий ч нийлүүлэлт хязгаарлалттай байгаатай холбоотой байна.

2025 онд Хятад улс нийт 120 сая тонн **коксжих нүүрс** импортолсон нь жилийн өмнөхөөс 3.0%-аар буурсан бөгөөд үүний 51%-ийг Монгол Улсаас импортолсон байна. 2025 оны сүүлээр Москвад болсон хоёр талын уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхий сайд Хятад руу экспортын хэмжээг жилд 100 сая тонн хүртэл нэмэгдүүлэх саналыг дэвшүүлсэн. Энэ зорилт биелэх боломжтой гэж үзэж байгаа бөгөөд Хятадын үйлдвэрлэлийн илүүдлийг хязгаарлах бодлого нь дотоодын нүүрсний нийлүүлэлтийг хязгаарлаж, импортыг өсгөх хандлагатай байна.

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ

3.1. Эдийн засгийн өсөлт, инфляцын түвшин

Монгол улсын хувьд 2024 онтой харьцуулахад 2025 онд эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй тогтворгүй байв. Эхний хагас жилд Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналтаас эхлэлтэй дотоод хэрэглээний зогсонги байдал болон АНУ-ын тарифын бодлогоос шалтгаалсан гадаад худалдааны эрсдэл БНХАУ-ын эдийн засгийн төлөвийг муутгаж БНХАУ-ын засгийн газраас нүүрсний гол эрэлтийг бүрдүүлэгч гангийн үйлдвэрлэлийг бууруулах шийдвэр гаргасан. Мөн БНХАУ-ын дотоодын нүүрсний уурхайнуудын олборлолт өндөр байсан нь импортын эрэлтийг бууруулж олон улсын зах зээлд коксжих нүүрсний үнэ огцом унасан билээ.

Эдийн засгийн өсөлтийн хувьд нүүрсний экспортын орлого багассанаар уул уурхайн салбарын өсөлтийг хязгаарлаж, бусад уул уурхайгаас хамааралтай салбаруудад сөрөг нөлөөлөл үзүүлсэн ба эдийн засгийн өсөлтийг уул уурхайн бус салбарууд дэмжсэн жил болов.

Тухайлбал 2025 оны эхний 3 улирлын гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон эдийн засгийн өсөлт 5.9%-тай гарсан ба цаг уурын таатай нөхцөл байдлаас шалтгаалан өмнөх жилүүдийн зудын хүндрэлээс сэргэсэн хөдөө аж ахуйн салбар нийт өсөлтийн 3.4 нэгж хувийг дангаар бүрдүүлжээ. Хаваржилт тогтуун байж, мал төллөлт, бойжилт хэвийн үргэлжилсний үр дүнд бойжсон төлийн тоо толгой 21.6 саяд хүрч өмнөх оны

мөн үеэс 5.6 сая толгой малаар нэмэгдэн, том малын зүй бус хорогдол 199 мянга болж, өмнөх оны мөн үеэс 9.1 сая толгой малаар буурсан байна.

График. 3 Монголын эдийн засгийн өсөлт 2025 оны 3-р улирал



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Цаашлаад барилгын салбар 2025 онд орон сууц, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай, Хөшигтийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын голлох нөлөөгөөр эдийн засгийн өсөлтийг 0.4 нэгж хувиар дэмжсэн байна.

Харин уул уурхайн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтийн 1.1 нэгж хувийг бүрдүүлсэн ба тээвэр болон худалдаа зэрэг уул уурхайгаас хамааралтай бусад салбаруудын өсөлт саарч, нийт эдийн засгийн өсөлтөөс 0.9%-аар хойш татжээ.

Хүснэгт. 1 Эдийн засгийн өсөлтөд салбаруудын оролцоо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, САЛБАРААР	Оролцоо	Жилийн өсөлт
ДНБ	**5.9%**	
ХАА	**3.4%**	**33.8%**
Уул уурхай	1.1%	8.2%
Боловсруулах	0.5%	7.7%
Цахилгаан, хий, уур, усан хангамж	0.2%	8.4%
Барилга	0.4%	22.2%
Бөөний, жижиглэн худалдаа	**-0.6%**	**-5.1%**
Тээвэр	**-0.3%**	**-6.1%**
Мэдээлэл холбоо	0.4%	10.0%
Үйлчилгээний бусад	1.2%	4.2%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	**-0.3%**	**-1.8%**

Эх сурвалж : Үндэсний статистикийн хороо

Инфляц 2025 оны эцэст 7.5% болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлтийн хурд 0.8 нэгж хувиар буурсан байна. Инфляц 7.5% гарсны 3.0 нэгж хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлэг, 0.9 нэгж хувь нь хувцас бөс бараа гутлын бүлгийн үнийн өсөлтөөс

шалтгаалжээ. Харин бараа, үйлчилгээний бүлгүүдийн үнийн өсөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад даатгал, санхүүгийн үйлчилгээ 15.3%-аар, хүнсний бараа ундаа, усны бүлэг 11.3%-аар, боловсролын үйлчилгээ 12.8%-аар тус тус хамгийн ихээр өсжээ.

График. 4 Инфляц ба бодлогын хүү



Эх сурвалж: Монголбанк

2025 оны сүүлийн хагаст ургац хураалт, махны үнийн хэлбэлзэл зэргээс шалтгаалан хүнсний инфляц нэмэгдсэн ч оны эцэст инфляц бага түвшинд байна. Инфляц ийнхүү буурахад төрийн зохицуулалттай бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн өсөлтийн суурь нөлөө арилсан нь голлон нөлөөлжээ.

Хэдийгээр инфляц 2025 оны эцэст төв банкны зорилтот интервалд хүрч буурсан ч инфляцыг өсгөх эрсдэлт хүчин зүйлс давамгайлсан хэвээр байгааг Монголбанкнаас онцолж байна. Улмаар 2025 оны 12-р сарын 10, 11-ний ээлжит хурлаар бодлогын хүүг 12%-д хэвээр хадгалах шийдвэр гаргасан бол 2026 оны 1-р сарын 16-нд болсон ээлжит бус хурлаар банкны системийн зээлийн өсөлтийг зохистой түвшинд хадгалах зорилгоор хэрэглээний зээлийн өр орлогын харьцааны дээд хязгаарыг 45% болгох, банкнуудын төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг тус бүр 1 нэгж хувиар нэмэгдүүлж, харгалзан 14 хувь болон 19 хувьд хүргэх шийдвэрүүдийг гаргаад байна.

3.2. Мөнгөний үзүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.7%-аар өсөхөд эх үүсвэр (пассив) талаас иргэд болон байгууллагын хадгаламж өссөн нь голлон нөлөөлсөн бол төгрөг болон гадаад валютын харилцах өмнөх оноос буурсан нь сөргөөр нөлөөлжээ.

Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 9.3 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 1.8 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -1.1 нэгж хувийг төгрөгийн харилцах, -1.3 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлж байна. Төгрөгийн хадгаламж 2025 оны эцэст 26.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.0 их наяд төгрөг буюу 18.3 хувиар өссөн байна.

Төгрөгийн хадгаламжийн 82.6 хувийг иргэдийн хадгаламж, 17.2 хувийг аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж бүрдүүлж байна. Түүнчлэн валютын хадгаламж 5.6 их наяд төгрөг болж өмнөх оноос 776.3 тэрбум төгрөгөөр буюу 16%-аар өсжээ. Харин төгрөгийн харилцах өмнөх оноос 4.5%-аар, валютын харилцах 12%-аар тус тус буурсан байна.

График. 5 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

3.3. Улсын төсөв

2025 оны эцэст улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого 30.0 их наяд төгрөг болж өмнөх оноос 1.3%-аар өслөө. Улсын төсвийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад ийнхүү 386 тэрбум төгрөгөөр өсөхөд нийгмийн даатгалын орлого 18.9%-аар өсөж 5.6 их наяд төгрөг, НӨАТ-ын орлого 6.1%-аар өсөж 6.2 их наяд төгрөг хүрсэн нь голлон нөлөөлсөн байна. Хэдийгээр улсын төсвийн орлого өссөн ч нүүрсний үнийн уналттай холбоотойгоор экспортын орлого буурч, аж ахуй нэгж байгууллагуудын орлогын албан татвар болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогууд өмнөх онтой харьцуулахад буурчээ.

График. 6 Улсын төсвийн гүйцэтгэл



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Улсын төсвийн зардал 2025 онд 31.3 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.3%-аар өсчээ. Улсын төсвийн зардлын 37.6%-ийг урсгал шилжүүлэг, бараа үйлчилгээний зардал 32.2%-ийг, хөрөнгийн зардал 22.7%-ийг эзэлж байна. Улмаар улсын төсвийн тэнцэл 2025 оны эцэст 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.

2026 оны төсөв:

2026 оны төсвийн танилцуулгад төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 31.6 их наяд төгрөг, төсвийн зардал 32.9 их наяд төгрөгт хүрэхээр баталсан. Улмаар улсын төсвийн алдагдал 1.4 их наяд төгрөг байхаар батлагдаж үүнийг Засгийн газрын гадаад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр бүрэн санхүүжүүлэхээр тусгажээ. Улсын төсвийг батлахдаа эдийн засгийн өсөлтийг 2026-2028 оны 5.4%-5.8% хүрэх, нүүрсний хилийн үнийг тонн тутамд 88-95 хүргэх тооцооллуудыг ашиглажээ.

График. 7 2026 төсвийн төсөл, төсвийн орлогын бүрэлдэхүүн, их наяд төгрөг



Эх сурвалж: Улсын төсвийн танилцуулга 2026

Гадаад орчны тодорхойгүй байдал 2026 онд ч үргэлжилж экспортын голлох түүхий эдийн үнэ, эрэлт буурах, улмаар манай улсын голлох салбаруудын өсөлт удаашрах зэрэг эрсдэлүүд хэвээр хадгалагдаж байна. Улмаар төсвийн орлогын төсөөлөлд ашигласан суурь таамаглалууд хүлээлтэд хүрэхгүй байх тохиолдолд төсвийн орлого тасалдах эрсдэлтэй.

Харин ирэх онд батлагдсан төсвийн зардлын 78% нь буюу 24.9 их наяд төгрөг нь урсгал зардал бол үлдсэн 22% нь хөрөнгийн зардал байна. Улсын төсвийн танилцуулгад дурдсанаар урсгал зардлын ДНБ-д эзлэх хувийг 24%-д хязгаарлахаар тусгасан байна.

Төсвийн зардал сүүлийн 3 жилд 8.8 их наяд төгрөгөөр буюу 39%-аар өссөн. Төсвийн хэт тэлэлт нь хэрэглээний импортыг нэмэгдүүлэх замаар инфляцыг өдөөж, ханшид дарамт учруулдаг тул тогтвортой түвшинд барих нь чухал юм. Түүнчлэн төсвийн алдагдал нэмэгдэхийн хэрээр түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр шаардлагатай болох ба энэ нь дунд хугацаанд улсын өрийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй.

3.4. Гадаад худалдаа

2025 оны хувьд нүүрсний экспортын орлого (12-р сарын эцсийн байдлаар 5.6 тэрбум ам.долларт хүрч өмнө оны мөн үеэс 34.8%-аар буурсан) огцом буурсан ч Оюу Толгойн далд уурхайн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотойгоор зэсийн баяжмалын орлого нэмэгдэж экспортыг дэмжлээ.

График. 8 Экспорт, импортын өсөлт



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

2025 оны эхний хагас жилд Монгол улсын Хятад улсруу экспортлох чулуун нүүрсний биет хэмжээ болон үнийн түвшин өмнө оны мөн үетэй харьцуулахад хоёул бууралттай байсан ч 7-р сараас эхлэн Хятадын дотоод дефляцитай тэмцэх хүрээнд явуулсан нүүрсний хэт үйлдвэрлэлийг бууруулах (Anti-Involution) бодлогын үр дүнд сүүлийн хагаст нүүрсний экспортын орлого тогтворжиж гадаад худалдааны алдагдал буурлаа. 2025 онд чулуун нүүрсний экспортын биет хэмжээ 83.9 сая тонн-д (2024 онтой харьцуулахад 6.0%-ийн өсөлт) хүрсэн бол жилийн дундаж хилийн үнэ тонн тутамд 66.3 ам.доллар болж 2024 оноос 38.3%-аар буурчээ. (2024 онд жилийн дунджаар чулуун нүүрсний үнэ 107.4 ам.доллар/тонн байв)

Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 2.3 сая тонн-д хүрсэн нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 34.6%-аар, харин хилийн дундаж үнэ тонн тутамд 2,546 ам.долларт хүрсэн нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 30%-аар өссөн үзүүлэлт болов. (2025 онд дэлхийд цэвэр зэсийн үнэ тонн тутамд 12,423 ам.долларт хүрсэн) Улмаар зэсийн нийт экспортын орлого 5.8 тэрбум ам.долларт хүрсэн нь 2024 онтой харьцуулахад даруй 75.0%-аар өссөн өндөр гүйцэтгэл юм. Ийнхүү жилийн эцсийн гүйцэтгэлээр экспортын

нийт орлогын 37.0%-ийг зэсийн баяжмал, харин 35.4%-ийг чулуун нүүрсний экспортын орлого бүрдүүлж зэс тэргүүлэх түүхий эд боллоо.

График. 9 Импортын бүтээгдэхүүн



Эх сурвалж: Монголбанк

График. 10 Экспортын орлого



Эх сурвалж: Монголбанк

График. 11 Нүүрсний экспортын биет хэмжээ



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

2025 онд нийт экспортын орлого 15.7 тэрбум ам.долларт хүрч өмнө оны мөн үеэс 0.5%-аар буурсан бол импортын зардал 11.3 тэрбум ам.долларт хүрч 2.6%-аар буурчээ. Улмаар худалдааны тэнцэл эерэг буюу 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнө оны мөн үеэс 5.3%-аар өссөн байна. (Эхний хагас жилд худалдааны ашиг өмнө оны мөн үетэй харьцуулахад 58.0%-ийн бууралттай байв)

3.5. Төлбөрийн тэнцэл, ханш

Худалдааны ашиг нэмэгдсэнээр урсгал дансны алдагдал буурч 2025 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 1.5 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнө оны мөн үеэс 19.3%-аар буурсан үзүүлэлт юм. (2024 оны эхний 11 сард урсгал дансны алдагдал 1.9 тэрбум ам.долларт хүрч байв) Урсгал дансны алдагдал буурч байгаа нь сүүлийн саруудад төлбөрийн тэнцэл ашигтай гарахад эерэг нөлөөлөл үзүүлж байгаа бол 2025 оны туршид санхүүгийн дансаар орж ирэх валютын урсгал өндөр байсан нь төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөллөө.

Тухайлбал 2025 он гарснаас хойш засгийн газар болон бусад томоохон аж ахуйн нэгжүүд олон улсын зах зээлд бондын санхүүжилт амжилттай татаж эхний 11 сарын гүйцэтгэлээр санхүүгийн дансны ашиг 1.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Ийнхүү төлбөрийн тэнцэл 11-р сард хуримтлагдсан дүнгээр 66 сая ам.долларын ашигтай гарч ханш тогтвортой хадгалагдав.

Мөн 2025 оны эцсийн гүйцэтгэлээр гадаад валютын албан нөөц 7 тэрбум ам.доллар буюу 7 сарын импортыг хангах хэмжээнд хүрлээ. Ингэснээр 12-р сарын төлбөрийн тэнцлийн ашиг өндөр гарах, ханш тогтвортой хадгалагдах дохио болсон ба 12-р сарын эцэст ханш 3,557 төгрөг/ам.долларт хүрсэн нь эхний хагас жилтэй харьцуулахад 0.6%-аар чангарсан үзүүлэлт боллоо.

График. 12 Төлбөрийн тэнцэл, ГВАН, ханш



Эх сурвалж: Монголбанк

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

7575-1111 /1277/
eru@golomtbank.com
www.dua.golomtbank.com

Голомт банкны төв байр,
Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол Улс
SWIFT: GLMT MNUB

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.